МЭДЭЭ · 2026 оны 5-р сарын 19

АВЛИГЫН ХЭРГҮҮДИЙГ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛҮҮЛЛЭЭ



Энэхүү мэдээлэл нь иргэдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэд, олон нийтэд Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн талаарх ойлголт, хэргийн шийдвэрлэлтийг ойлгомжтой байдлаар мэдээлэх зорилготой.

Прокурорын байгууллага 2026 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэрэгтэй холбоотой яллах дүгнэлт үйлдсэн 94 хэргийг шүүхээр шийдвэрлүүллээ.

Нийслэл болон Өвөрхангай, Увс аймгийн прокурорын газраас өнгөрсөн долоо хоногт буюу 2026 оны 5 дугаар сарын 11-ний өдрөөс 5 дугаар сарын 15-ны өдрүүдэд анхан шатны шүүхээр 7 хүнд холбогдох 6 хэргийг шүүхээр шийдвэрлүүлж, шүүхээс 7 хүнийг авлигын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, хуульд заасан эрүүгийн хариуцлагыг оногдуулсан байна. Хэргийг тоймлон хүргэвэл:

Нийслэлийн прокурорын газраас:

- Ц.Б нь ...эрүүл мэндийн үндэсний төвийн тасгийн эрхлэгчээр ажиллаж байхдаа

холбогдох хууль, журмыг зөрчиж, албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, 2022 оны 1 дүгээр сараас 2022 оны 12 дугаар сар хүртэлх хугацаанд төрсний дараах тасгийн төлбөртэй өрөөнд хэвтэн эмчлүүлсэн 785 иргэнээс хураамж хэлбэрээр төвлөрсөн 44,2 сая төгрөгөөс 11,4 сая төгрөгийг Төрийн сан дахь дансанд төвлөрүүлж, 32,7 төгрөгийг нь байгууллагын касс, дансанд тушаалгүйгээр 10,2 сая төгрөгөөр нь тасгийн өрөөнүүдийг тохижуулах болон байгууллагын үйл ажиллагаанд зарцуулж, үлдсэн 22,4 сая төгрөгийг өөрийн хувийн хэрэгцээнд зарцуулж, өөртөө эдийн давуу байдал бий болгож, эрүүл мэндийн үндэсний төвд 22,4 сая төгрөгийн хохирол учруулсан хэрэгт Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт (Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах)-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлсэн.

> Шүүхээс Ц.Б-г эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, нийтийн албанд ажиллах эрхийг 2 жилийн хугацаагаар хасаж, 8 сая төгрөгөөр торгох ял оногдуулж, Ц.Б-с 12,6 сая төгрөгийг гаргуулж ... эрүүл мэндийн үндэсний төвд олгохоор шийдвэрлэсэн.

- Х.А нь “Э... цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Эдийн засаг хөгжлийн хэлтсийн төсөл хэрэгжүүлэх албаны дарга буюу нийтийн албан тушаалтнаар ажиллаж байхдаа албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, “Эрчим хүчний төсөл-2” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй “Орхон аймгийн Баян-Өндөр сумын 6-0,4 кВ-ын цахилгаан түгээх сүлжээг шинэчлэх, сайжруулах ажил”-ын төслийн хүрээнд баригдаж буй эрчим хүчний барилга байгууламжийг ашиглалтад оруулах тооллогын комиссын гишүүнээр ажиллахдаа “Р...” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Г-ээс барилга угсралтын ажлын 80 хувийн гүйцэтгэлийн тооллогын тайланд гарын үсэг зурж баталгаажуулсны хариуд бусдын дансаар дамжуулан 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдөр 25 сая төгрөг, мөн улсын комиссын дүгнэлтэд гарын үсэг зурж баталгаажуулсны хариуд 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдөр 20 сая төгрөг, нийт 45 сая төгрөгийн хахууль авсан хэрэгт Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг (Нийтийн албан тушаалтан хахууль авах)-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлсэн.

> Шүүхээс Х.А-г үргэлжилсэн үйлдлээр нийтийн албан тушаалтан хахууль авах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, нийтийн албанд ажиллах эрхийг 3 жилийн хугацаагаар хасаж, 1 жилийн хугацаагаар хорих ял оногдуулж, хахуульд авсан 45 сая төгрөгийг улсын орлого болгохоор шийдвэрлэсэн.

- Г.Р нь шүүхээс 3 жилийн хугацаатай зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлж, уг ялаа эдэлж байхдаа хуульд заасан үүргээ биелүүлээгүй, хянах төхөөрөмжийг удаа дараа унтрааж зөрчил гаргасан үйлдэлдээ зохих хариуцлага хүлээхгүй байх ашиг сонирхлын үүднээс, өөртөө давуу байдал бий болгох зорилгоор ... шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын шийдвэр гүйцэтгэгчид нэр бүхий компанийн 500 мянган төгрөгийн үнэ бүхий эрхийн бичгийг хахууль болгож өгөхийг завдсан хэрэгт Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг (Хахууль өгөх)-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлсэн.

> Шүүхээс Г.Р-г хахууль өгөхийг завдсан хэрэгт гэм буруутайд тооцож, нийтийн албанд ажиллах эрхийг 2 жилийн хугацаагаар хасаж, 2 сая төгрөгөөр торгох ял оногдуулж шийдвэрлэсэн.

- Ш.Н нь нийтийн албан тушаалтан буюу ... дүүргийн ... дугаар цэцэрлэгийн эрхлэгчээр ажиллаж байхдаа албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн тушаалаар Б.Э-г сэтгэл зүйчээр томилж, хөдөлмөр эрхлээгүй байхад нь 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс 12 дугаарын сарын 10-ны өдрийн хооронд нийт 2,7 сая төгрөгийн цалин бодож, гарт олгогдсон 1,9 сая төгрөгөөс 1,6 сая төгрөгийг иргэн Э.Б, Д.А нарын дансаар дамжуулан хувьдаа авсан,

Мөн “С...” ХХК-тай 2025 оны 8 дугаар сарын 18-ны өдөр 3 сая төгрөгийн үнийн дүнтэй худалдах, худалдан авах гэрээ байгуулж, 2025 оны 8 дугаар сарын 20-ны өдөр тус компанийн данс руу 3 сая төгрөг шилжүүлж, 2,7 сая төгрөгийг бэлнээр гаргуулан хувьдаа авч өөртөө эдийн давуу байдал бий болгож, 33 дугаар цэцэрлэгт нийт 5,7 сая төгрөгийн хохирол учруулсан хэрэгт Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт (Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах)-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлсэн.

> Шүүхээс Ш.Н-г эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, нийтийн албанд ажиллах эрхийг 2 жилийн хугацаагаар хасаж, хорих ял оногдуулахгүйгээр 1 жилийн хугацаагаар тэнсэж, үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авч, 3,7 сая төгрөгийн хохирол төлөгдсөн талаар дурдаж шийдвэрлэсэн.

Өвөрхангай аймгийн прокурорын газраас:

- Д.Н нь нийтийн албан тушаалтан буюу ... аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, үнэлгээний хорооны даргаар, Б.П нь үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж байхдаа бүлэглэн Засаг даргын 2019 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн А/307 дугаартай захирамжийн дагуу “...Эрүүл мэндийн салбарын их засвар тоног төхөөрөмж” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахдаа холбогдох хууль тогтоомжийг зөрчиж, тендерт оролцогчдоос зөөврийн компьютерийн үзүүлэлт “i7” гэсэн үзүүлэлт, шалгуурыг хангаагүй “Н... ” ХХК-ийг шалгаруулж, тус компанид давуу байдал олгож, төсөвт 86 сая төгрөгийн хохирол учруулсан хэрэгт Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт (Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах)-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлсэн.

> Шүүхээс Д.Н, Б.П нарыг эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, нийтийн албанд ажиллах эрхийг 3 жилийн хугацаагаар тус тус хасаж, Д.Н-д 7 сая төгрөгөөр торгох, Б.П-д 6 сая төгрөгөөр торгох ял оногдуулж, иргэний хариуцагч “Н... ” ХХК-иас 28,8 сая төгрөгийг гаргуулан тус аймгийн Засаг даргын тамгын газрын санхүү, төрийн сангийн хэлтэст

> олгохоор шийдвэрлэсэн.

Увс аймгийн прокурорын газраас:

- Б.С-ыг Увс аймгийн Бөхмөрөн сумын Засаг даргаар буюу нийтийн албан тушаалтнаар ажиллахдаа холбогдох хууль тогтоомжийг зөрчиж, албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, 2023 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн А/20 дугаартай захирамж гаргаж, ерөнхий боловсролын сургуулиас кадастрын зургаар 212 метр зайд, хүний явах замаар 240 метр зайд байршин үйл ажиллагаа явуулдаг иргэн Х.Б-ын эзэмшлийн “М...” хүнсний дэлгүүрт тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрөл олгож, бусдад давуу байдал бий болгосон гэх хэрэгт Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг (Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах)-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлсэн.

> Шүүх Б.С-ыг эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, нийтийн албанд ажиллах эрхийг 4 жилийн хугацаагаар хасаж, 3 жилийн хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулж шийдвэрлэсэн.

Иргэн танд:

Авлигын гэмт хэрэг нь хуулиар хамгаалсан нийгмийн ашиг сонирхлыг зөрчиж, тодорхой материаллаг хохирол учруулахаас гадна төрийн албанд хууль дээдлэх, шударга ёсыг хангах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалж ажиллах зарчмыг ноцтой зөрчиж, төрд итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулж, төрийн байгууллагын үнэлэмжийг сулруулах зэрэг хор уршиг учруулдгаараа нийгмийн аюулын шинж ихтэй.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/460